



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 15 өдөр

Дугаар А/Ц

Мандалговь

2020 оны сум, агентлагийн үйл ажиллагааны  
үр дүнг үнэлэх ажлын хэсэг байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1, 30.1.17 дахь заалт, Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын 9.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, Сумдын Засаг дарга түүний Тамгын газрын 2020 оны үйл ажиллагааны үр дүнд хяналт шинжилгээ хийж, үнэлгээ хийх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч:	Л.Доржбат	(Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)
Нарийн бичгийн дарга:	Г.Самданцоодол	(Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга)
Гишүүд:	М.Цогзолмаа	(Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга)
	Н.Эрдэнэ-Очир	(Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга)
	А.Нарантуяа	(Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)
	Б.Түвшинбаяр	(Хууль, эрх зүйн хэлтсийн дарга)
	Г.Энхтайван	(Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)
	Э.Одончимэг	(Хяналт шинжилгээ үнэлгээ дотоод аудитын хэлтсийн ахлах мэргэжилтэн)
	Д.Даариймаа	(Хяналт шинжилгээ үнэлгээ дотоод аудитын хэлтсийн мэргэжилтэн)
	Н.Дэлгэрмаа	(Хяналт шинжилгээ үнэлгээ дотоод аудитын хэлтсийн мэргэжилтэн)

Хоёр. Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, Сумдын Засаг дарга түүний Тамгын газрын 2020 оны үйл ажиллагааны үр дүнд хяналт шинжилгээ хийж, үнэлгээ өгөх удирдамж, аргачлалыг боловсруулан батлуулж, ажлын хэсгийг удирдлага арга зүйгээр хангаж ажиллахыг ажлын хэсэг (Л.Доржбат) -т үүрэг болгосугай.

Гурав. Сум, агентлагуудын үйл ажиллагааны үр дүнд хяналт шинжилгээ, хийж үнэлэх ажлыг 2021 оны 1 сарын 18-ны өдрөөс ажлын 15 хоногт багтаан удирдамж аргачлалын дагуу чанартай зохион байгуулж, дүнг нэгтгэн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулахыг ажлын хэсэг (Л.Доржбат), (Г.Самданцоодол) нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.МӨНХБАТ

481210030